



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/115

Өмнөдэлгэр сум

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг
судлан бүртгэх, орон тооны бус
байнгын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 269 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Мөнхбаяр Дотрын эмч


Гишүүд: Н.Ундармаа Эх баригч

Л.Алтанцэцэг Нийгмийн эрүүл мэндийн ажилтан

2.Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэж, акт тогтоон үүссэн шалтгаан нөхцөлд шуурхай арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг орон тооны бус байнгын комисст үүрэг болгосугай.

3.Үүссэн нөхцөл байдлын дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайланг тухай бүр сумын Засаг даргад танилцуулж ажиллахыг комиссын дарга (Б.Мөнхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Ц.АРИУНТУНГАЛАГ